



**ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН
ИХ СУРГУУЛИЙН РЕКТОРЫН
ТУШААЛ**

2009 оны 05 сарын 01 өдөр

Дугаар 162

Улаанбаатар хот

Журам батлах тухай

“Төрийн хяналт, шалгалтын тухай” хуулийн 13-р зүйлийн 13.1 дэх заалт, ШУТИС-ийн дүрмийн 4.11.3, 4.17.6 дах заалтууд, Ректорын зөвлөлийн 2009 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “ШУТИС-д ажиллаж буй ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг зохицуулах журам”-ыг 1-р хавсралтаар, “ШУТИС-ийн дотоодын хяналт шалгалтын журам”-ыг 2-р хавсралтаар тус тус баталж, 2009 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдсүгэй.

2. “ШУТИС-д ажиллаж буй ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг зохицуулах журам” батлагдсантай холбогдуулан “Профессор багш нарын ажлын кредит тооцох журам”-ын 1.9-р зүйлд дараах өөрчлөлтүүдийг оруулсугай. Үүнд:

- a. “Тэтгэвэрт гарсан эрдэмтэн, ахмад багш нарыг гэрээгээр зөвлөх профессороор ажиллуулж болно.” гэснийг “Өндөр насны тэтгэвэрт гарсан ахмад профессор, багшийг “ШУТИС-д ажиллаж буй ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг зохицуулах журам”-д заасны дагуу ажиллуулж болно.” гэж өөрчлөх;
- b. “Профессорын багт зөвлөх профессорын орон тоо 1-ээс илүүгүй байна.” гэсний дараа “Өндөр насны тэтгэвэр тогтоолгоод ахлах багшийн 50%, 25%-ийн албан тушаалд гэрээгээр ажиллах багшийн заавал биелүүлэх сургалтын ноогдол кредит, цалингийн хэмжээг харгалзах хувиар тогтооно.” гэж нэмэх;
- c. Зөвлөх профессорын заавал биелүүлэх сургалтын кредитийн ноогдол “4” гэснийг “2” гэж өөрчлөх;

3. Батлагдсан журмуудыг хэрэгжүүлж ажиллахыг Сургалтын проректор (Я.Наранцэцэг), Эдийн засаг, нийгмийн хөгжлийн проректор (Б.Даваасүрэн), Ректорын ажлын алба (Д.Батбаяр), холбогдох албан тушаалтнуудад үүрэг болгосугай.




РЕКТОР **Б.ДАМДИНСҮРЭН**



162
Ректорын 2009 оны ... тоот
тушаалын 2-р хавсралт

ШУТИС-ИЙН ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 ШУТИС-ийн дотоод хяналт шалгалт нь Монгол улсын хууль, тогтоомж болон ШУТИС-ийн дүрэм журам, Ректорын тушаал, шийдвэрийн хэрэгжилт, санхүү, өмч хөрөнгийн бүртгэл тооцоо, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, сургалтын үйл ажиллагаанд хяналт тавьж, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчил дутагдлыг илрүүлж арилгуулах замаар хууль тогтоомж, стандартыг нийтээрээ хэрэгжүүлдэг хэвшил тогтооход оршино.
- 1.2 Дотоод хяналт шалгалт нь ил тод, шударга, бодитой байх зарчимд үндэслэнэ.
- 1.3 Дотоод хяналт шалгалтыг зохих хууль, журмын хүрээнд батлагдсан удирдамжийн дагуу явуулна.
- 1.4 Дотоод хяналт шалгалтыг тодорхой бус гомдол, нэр, хаяггүй мэдээллээр явуулахыг хориглоно.
- 1.5 Дотоод хяналт шалгалт нь дараах хэлбэрүүдтэй байна. Үүнд:
 - Төлөвлөгөөт ба төлөвлөгөөт бус
 - Орцын, явцын, гарцын
 - Байнгын ба гэнэтийн
- 1.6 Дотоод хяналт шалгалт нь хамрах хүрээг тогтоож удирдамж батлуулах, холбогдох хяналт шалгалт хийх, үнэлгээ дүгнэлт гаргах, зөвлөмж өгөх, тайлагнах үе шатуудтай байна.
- 1.7 Энэхүү журмыг ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургууль, хүрээлэн, төв, бусад нэгжийн үйл ажиллагаанд дотоодын хяналт хийхэд мөрдөнө. Харьяа сургуулиудад зөвхөн сургалтын үйл ажиллагаанд тавих хяналт шалгалтыг хэрэгжүүлнэ.

Хоёр. Байгууллагын дотоод үйл ажиллагаанд тавих хяналт шалгалт

- 2.1 Их сургуулийн хэмжээнд мөрдөгдөх дүрэм журмуудыг Монгол улсын хууль тогтоомжид нийцүүлэн гаргах, хууль тогтоомж, удирдах дээд байгууллагын шийдвэр, их сургуулийн дүрэм, журам, заавар, Ректорын тушаал, шийдвэрийн биелэлтэнд хяналт тавих үүргийг Ректорын ажлын алба хүлээнэ.
- 2.2 Холбогдох хууль, тогтоомж, тушаал шийдвэр(хугацаатай, хугацаагүй)-ийн холбогдох зүйл, заалт бүрээр "Архив, албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар"-ын дагуу бүртгэл хөтлөх, хэрэгжүүлэх, профессор, багш, ажилтан, ажилчдын нийгмийн даатгалын дэвтэр, хувийн хэрэгт зохих тэмдэглэл, баяжилт хөдөлгөөн хийх, сахилга дэг журам, ажлын цаг ашиглалтанд хяналт тавих ажлыг Ректорын ажлын алба, сургууль, хүрээлэн, төвийн захирал, захирлын туслах нар хариуцан гүйцэтгэнэ.
- 2.3 Бүрэлдэхүүн сургууль, хүрээлэн, төв, газар нэгжүүд өөрийн дотоод үйл ажиллагааны ажил хэрэгч, шуурхай байдалд байнгын хяналт тавьж, зарчимч шаардлага, шударга шүүмжлэлийг дээдлэн, сургуулийн хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолтонд заасан ажлын байранд тавигдах шаардлагыг чанд баримталж ажиллана.

Гурав. Сургалтын үйл ажиллагаанд тавих хяналт шалгалт

- 3.1 Их сургуулийн сургалтын үйл ажиллагааны хэвийн нөхцөлийг хангах, хяналт тавих, шаардлагатай арга хэмжээ авч ажиллах үүргийг Сургалтын проректор, Сургалтын бодлого зохицуулалтын газрын дарга, бүрэлдэхүүн болон харьяа сургуулийн захирал хүлээнэ.

- 3.2 Сургалтын нэгдсэн хуанли, хичээлийн нэгдсэн хуваарь, хичээлийн стандартын дагуу сургалтын үйл ажиллагаа явагдаж буйд өдөр тутам хяналт тавьж, илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүрд нь засаж, залруулах ажлыг сургалтын хяналт хариуцсан мэргэжилтэн, бүрэлдэхүүн болон харъяа сургуулийн дэд захирал, тэргүүлэх профессор, тэнхмийн эрхлэгч нар хариуцан гүйцэтгэнэ.
- 3.3 Оюутны хичээллэлтийн явц, үр дүн, хичээлийн ирцэд тавих хяналтыг тэргүүлэх профессор, тэнхмийн эрхлэгч, зөвлөх багш, сургалтын албаны ажилтан нар хариуцна.
- 3.4 ШУТИС-ийн “Профессор багш нарын ажлын кредит тооцох журам”-ын дагуу профессор, багш нарын гүйцэтгэсэн кредитийн тооцоог тэргүүлэх профессор, тэнхмийн эрхлэгч хийж, дэд захирал хянан, захирал баталгаажуулна.

Дөрөв. Санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт

- 4.1 Санхүүгийн хяналтыг их сургуулийн дотоод аудит хариуцсан мэргэжилтэн зохих зөвлөмж, удирдамжийн дагуу дараах чиглэлээр явуулна. Үүнд:
 - 4.1.1 Сургууль, нэгжийн өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтын байдал
 - 4.1.2 Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн аргачлал, заавар, журам, стандартын хэрэгжилт
 - 4.1.3 Төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл, зардлын нормын мөрдөлт

Тав. Авах арга хэмжээ, хүлээх хариуцлага

- 5.1 Дотоод хяналт шалгалтын үр дүнг Ректорын зөвлөлийн болон захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, зохих шийдвэрийг гаргуулна.
 - 5.1.1 Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгах, зөрчлийн улмаас сургуульд учирсан хохирлыг буруутай этгээдээр төлүүлэх ба хохирлыг хэд хэдэн албан тушаалтан хариуцахаар бол суутгалыг албан тушаалтан тус бүрт тогтоосон хувь хэмжээгээр ногдуулна.
 - 5.1.2 Хөдөлмөрийн гэрээгээр болон албан тушаалын тодорхойлолтод заасан ажил үүргээ хангалтгүй биелүүлсэн, сургуульд мөрдөж байгаа дүрэм, журам, зааврыг зөрчсөн, хугацаатай үүрэг даалгаврыг хугацаанд нь биелүүлээгүй албан тушаалтнуудад Хөдөлмөрийн тухай хууль болон сургуулийн хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу Ректорын болон захирлын шийдвэрээр сахилгын шийтгэл ногдуулна.